



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/90

Улаанбаатар хот

“Цусны донорын Үндэсний өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Төвийн “Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам”, Удирдлагын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хурлын шийдвэр, Захиргаа, маркетингийн албаны даргын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цусны донорын Үндэсний өдөр”-ийг 2023 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэх удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, арга хэмжээний төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврах, цус цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор олон удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ авлагагүйгээр бэлэглэсэн цусны донор, донор хамт олон, цусны донорын үйлсийг дэмжиж хамтран ажилладаг байгууллагуудыг “Цусны донорыг алдаршуулах, урамшуулах журам”-д заасны дагуу урамшуулсугай.

3. Удирдамж, төсвийн дагуу “Цусны донорын Үндэсний өдөр”-ийг зохион байгуулж, дүнг танилцуулахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д даалгасугай.

4. Энэ тушаалын 2 дугаар хавсралтад заасан зардлыг хөтөлбөр, төслийн зардлаас зарцуулахыг Санхүү, бүртгэлийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч /Х.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБЯАР



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 1190 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

2023 ОНЫ “ЦУСНЫ ДОНОРЫН ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ИЙГ
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ УДИРДАМЖ

Зорилго:

ЦССҮТ-өөс санаачлан “Цусны донорын Үндэсний өдөр”-ийн хүрээнд ард иргэдэд авлагагүй, сайн дурын цусны донорын үйлсийг сурталчлах, цусаа бэлэглэхийн ач холбогдлын талаар мэдээлэл өгөх, олон удаа цусаа өгсөн байнгын донорыг алдаршуулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Зорилт:

- 1.Цусны донорын үйлсийг олон нийтэд сурталчлах, ард иргэдэд эрүүл зан үйл төлөвшүүлэхэд нөлөөлөх, цусаа өгөхийн ач тусыг таниулах нөлөөллийн ажлыг хийнэ.
- 2.Цусны донорын эгнээг өргөжүүлж, олон удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн байнгын доноруудыг урамшуулж, донор хадгалалтыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Нээлтийн үйл ажиллагааг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах
- 2023 оны 1 сарын 3-ны Цусаа бэлэглэх Үндэсний өдрийг зохион байгуулах
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр донорын үйлсийг сурталчлах
- Донорын үйлсэд хамтран ажиллдаг байгууллагуудыг алдаршуулах
- 2022 оны топ өгөлттэй доноруудыг алдаршуулах, урамшуулах
- Тогтмол хугацаанд цусаа бэлэглэж байгаа “Хүндэт донор”-уудыг “Алт, Мөнгө, Хүрэл” донороор өргөмжлөх
- Бахархал 10, 20, 30, 40, 50 тэмдгээр доноруудыг алдаршуулах
- Цус өгөлтийн удаагаар нь 10-21 оноотой доноруудад онооны урамшуулал олгох

Хугацаа:

2023 оны 01 дүгээр сарын 03 өдөр

Гарах үр дүн:

- Донорын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
- Хүн амын дунд авлагагүй, сайн дурын цусны донорын талаарх мэдлэг, хандлага сайжирч байнгын донорын тоо нэмэгдэнэ.
- Цусаа бэлэглэгч доноруудын нэр хүнд өсч, тэдний сайн үйл нийгэмд танигдана.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 11-р дугаар тушаалын
2 дугаар хавсралт

1118266548 9126905

2023 ОНЫ “ЦУСНЫ ДОНОРЫН ҮНДЭСНИЙ ӨДӨР” ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Уриа: Цусаа бэлэглэж, эв нэгдлийг эрхэмлэн бусдын амь насыг аварцгаая!

№	Шагналын нэр	Тоо хэмжээ	Огноо	Зарцуулагдах төсөв	Тайлбар
1. Байгууллага хамт олоныг алдаршуулах					
1.	“Цусны донор” хамт олон	3	2022.12.12	60.000*3=180.000₮	Төсвийн санхүүжилт
		Өргөмжлөл			
	Гарын бэлэг	2022.12.12	300.000*3=900.000₮		
2.	“Тэргүүний донор элсүүлэгч” байгууллага	1	2022.12.12	60.000*1= 60.000₮	
		Өргөмжлөл			
	Гарын бэлэг	2022.12.12	300.000*1= 300.000₮		
3.	Хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч байгууллага	2	2022.06.13	60.000*2= 120.000₮	
		Өргөмжлөл			
4.	Гарын бэлэг	2022.12.12	300.000*2= 600.000₮		
	ДҮН			2.160.000₮	
2. Цусны донорыг алдаршуулах					
5.	Жилийн хамгийн олон өгөлттэй донорын Цом, гарын бэлэг	2	2022.12.12	60.000*2= 120.000₮	Төсвийн санхүүжилт
6.		2			
7.	Жилийн хамгийн олон өгөлттэй залуу донорын Цом, гарын бэлэг	1	2022.12.12	60.000*1= 60.000₮	
8.		1			
9.	Алтан донорын гарын бэлэг	1	2022.12.12	500.000*1= 500.000₮	

10	Мөнгөн донорын гарын бэлэг	1	2022.12.12	400.000*1= 400.000₮	
11	Хүрэл донорын гарын бэлэг	1	2022.12.12	300.000*1= 300.000₮	
12	Бахархал 10, 20, 30, 40, 50 тэмдэг	5	2022.12.12	100.000*5= 500.000₮	
	ДҮН			2.480.000₮	
3. Арга хэмжээний нээлт, мэндчилгээ					
13.	Хөтлөгч, урлагын номер "Морин хуурч"	1	2022.12.12	1.300.000*1= 1.300.000₮	Төсвийн санхүүжилт
14.	Сурталчилгааны материал хийлгэх	20	2022.12.12	50.000*20= 1000.000₮	
15.	Хулдаасан хэвлэл	1	2022.12.12	90.000*1= 90.000₮	
	ДҮН			2.390.000₮	
16	Угтах үйлчилгээ цай, ус, бэлэн бүтээгдэхүүн		2022.06.13	300.000₮	Төсвийн санхүүжилт
	Нийт дүн			7.330.000₮	